



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 213

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Талын зам” АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн Улсын байцаагчийн баримтын шалгалтаар нийт 226.2 сая (хоёр зуун хорин зургаан сая хоёр зуун мянган төгрөг) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Талын зам” АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын биелэлтээр “Талын зам” ТӨХК нь 68.3 хувь буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” гэсэн үнэлгээ авсан байх тул цаашид биелэлтийг бүрэн хангаж ажиллах;

3. “Талын зам” АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлж ажиллахыг зөвлөсүгэй.

3.1. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах;

3.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталж өгсөн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон Гүйцэтгэх захиралтай байгуулсан контракт болон “Төрийн өмч эзэмшүүлэх гэрээ”-ээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

4. “Талын зам” АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал А.Түвшинмөнхөд дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай:

4.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

4.2. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

4.3. Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 02 сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.3-д заасан “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх,

132002509

удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх тухай заалтын мөрдөж ажиллах;

4.4.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан Контрактаар олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд туссан зардлаас бусад зардлыг санхүүжүүлэхгүй байх;

4.5.Компанийн тайланд бүртгэлтэй байгаа он удаан жилийн насжилттай 26.7 сая төгрөгийн авлагын асуудлыг судалж, авлагыг барагдуулах асуудалд хууль хяналтын байгууллагатай хамтарч ажиллах;

4.6.Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах;

4.7.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэж заасныг мөрдлөг болгон ажиллах;

4.8.“Талын зам” ТӨХК нь 2020 онд орон нутгийн тендерээр Баруун-Урт сумын 1-р баг 60 айл, грийн таун хорооллоос музей чиглэлийн авто замын ажил гүйцэтгэх тендертэй холбоотой шинээр үүсээд байгаа “Ханан салхит” ХХК-ийн нэхэмжлэлтэй 71,3 сая төгрөгийн асфальтны нэхэмжлэлд хуулийн дагуу үндэслэлтэй тайлбар өгөх, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хууль зүйн туслалцаа авах;

4.9.2021 оны жилийн эцсийн тооллогын дагуу удаан жил ашиглагдаж, элэгдлээрээ анхны үнээ нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон 25 нэр төрлийн 11.7 сая төгрөгийн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

5.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай тогтоолын биелэлт болон илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

6.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн
~~333~~ дугаар тогтоолын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга
хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлээгүй бараа, ажил үйлчилгээ	Захирал Б.Түвшинмөнх Ерөнхий ня-бо Б.Ганболор	125,805.21	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмыг мөрдөж ажиллах
2	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс гадуур худалдан авсан үндсэн хөрөнгө	Захирал Б.Түвшинмөнх Ерөнхий ня-бо Б.Ганболор	8,844.40	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах
3	Гэрээ дүгнэсэн актгүй санхүүжүүлсэн бараа, ажил үйлчилгээний зардал	Захирал Б.Түвшинмөнх Ерөнхий ня-бо Б.Ганболор	91,414.05	Нягтлан бодох бүртгэлийн хуулийг мөрдөж ажиллах
4	Хуулийн дагуу суутгаж аваагүй хувь хүний орлогын албан татвар	Захирал Б.Түвшинмөнх Ерөнхий ня-бо Б.Ганболор	105.00	Хувь хүний орлогын албан татварын хуулийг мөрдөж ажиллах
	Дүн		226,168.66	